



## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Биеийн тамир спортын тухай хууль, "Нийтийн биеийн тамир, спортын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэхүү тэмцээний зорилго оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

#### 2.1. Спортын төрөл:

- 2.1.1. Сагсан бөмбөг /эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 10 хүртэлх тамирчин/
- 2.1.2. Волейбол /эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 10 хүртэлх тамирчин/
- 2.1.3. Шатар /эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 3 тамирчин/
- 2.1.4. Ширээний теннис /эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 3 тамирчин/
- 2.1.5. Дартс /эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 3 тамирчин/
- 2.1.6. E-sport, Дота 2 /эрэгтэй, эмэгтэй харгалзахгүй нийт 6 хүртэлх тамирчин/

2.2. Тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд зохион байгуулна. /Тэмцээн болох өдөр, цаг, зохион байгуулах газрыг техникийн зөвлөгөөний үеэр эцэслэн зарлана/

2.2.1. Сагсан бөмбөг, волейболын тэмцээн 2025 оны 3 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд "Буянт-Ухаа спорт цогцолбор"-т зохиогдоно.

2.2.2. Шатрын тэмцээн 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн яамны хурлын Б зааланд.

2.2.3. Ширээний теннисний тэмцээн 2025 оны 3 дүгээр сарын 25-ны өдөр "Оч" клубийн зааланд зохиогдоно.

2.2.4. Дартсын тэмцээн 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр "Буянт-Ухаа спорт цогцолбор"-т зохиогдоно.

2.2.5. E-sport 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр "The Meta E-sport center"-т зохиогдоно.

2.3 Тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлэг хүлээн авах

өмнө тэмцээн зохион байгуулах комиссын цахим шуудан [/sport@moh.gov.mn/](mailto:/sport@moh.gov.mn/) хаягаар ирүүлнэ. Тэмцээнд оролцох тамирчид журамд заасан баримт бичгийг цээж зургийн хамт хавсарган ирүүлэхдээ өөрийн овог нэр, гар утас, байгууллагын нэр зэрэг мэдээллийг заавал бичнэ.

#### 2.4 Тэмцээний техникийн зөвлөгөөн

2.4.1 Техникийн зөвлөгөөн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Эрүүл мэндийн яамны Б хурлын зааланд 14:00-16:00 цагийн хооронд явагдана.

2.4.2 Техникийн зөвлөгөөнд Ерөнхий шүүгч, төрөл тус бүрийн ахлах шүүгч, зохион байгуулагчдын төлөөлөл, тэмцээнд оролцох байгууллагын багийн ахлагч 1 тамирчны хамтаар оролцоно.

2.4.3 Техникийн зөвлөгөөнөөр тоглолтын дэг, хуваарь, хугацаа, оноолтыг эцэслэнэ.

#### 2.5 Тэмцээний нээлт хаалтын үйл ажиллагаа

2.5.1 “Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээн”-2025 тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 14 цагт “Буянт-Ухаа спорт цогцолбор”-т болох бөгөөд баг, тамирчид бүрэн бүрэлдэхүүнээр оролцоно.

2.5.2. Тэмцээний нээлтэд Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд оролцоно.

2.5.3. Тэмцээний медальт байранд шалгарсан баг, тамирчдын шагнал гардуулах хаалтын ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Буянт-Ухаа спорт цогцолбор”-т болно.

2.5.4. Тэмцээний нээлт, хаалтын жагсаалд спорт зааланд баг тамирчид байгууллагын туг, далбаатай жагсана.

#### **Гурав. Тэмцээний зохион байгуулалт, онцлог, хамрах хүрээ**

3.1 Тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 3 дугаар сарын 10-ны өдрүүдэд бүсчилсэн байдлаар зохион байгуулж, бүсээс шалгарсан багуудыг Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэмцээнд оролцуулна.

3.1.1 Орон нутаг 5 бүсэд дараах байдлаар хуваагдана

1. Баян – Өлгий, Ховд, Увс, Говь – Алтай
2. Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Завхан
3. Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан
4. Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Төв аймаг
5. Дорнод, Хэнтий, Сүхбаатар

3.1.2 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд 3.1.1-т заасан хэсэг тус бүр Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрлөөр 2025 оны 02 дугаар сарын 17-с 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор тэмцээнээ зохион байгуулж, төрөл бүрээс нэгдүгээр байранд орсон аймаг бусад аймгуудаас өөрсдийн хүсэлтээр шигшээ багаа бүрдүүлнэ. Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахаар энэ журмын 2.3.1-д заасны дагуу мэдүүлгийг ирүүлэх. Тухайн орон нутгийн хувийн хэвшлийн эмнэлгүүд, өрх сумын эмч нар аймгийн багтаа нэгдэж орно.

### 3.1.3 Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллага

НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллагууд Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрлийн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 17-с 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, төрөл бүрд эхний 3 байранд орсон багуудыг Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахаар энэ журмын 2.3.1-д заасны дагуу мэдүүлгийг ирүүлэх.

### 3.1.4 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрлийн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 17-с 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, төрөл бүрд эхний 3 байранд орсон багуудыг Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахаар энэ журмын 2.3.1-д заасны дагуу мэдүүлгийг ирүүлэх.

### 3.1.5 Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага

ЭМЯ-ны харьяа байгууллагууд Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрөлт Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд 03 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд оролцуулах.

### 3.1.6 Тусгай эмнэлэг

Тусгай эмнэлгийн төлөөллүүдийг Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрөлт Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд 03 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд оролцуулах.

### 3.1.7 Өрхийн эрүүл мэндийн төв

Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооноос Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, E-sport (DOTA 2) нийт 6 төрлийн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 17-с 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, төрөл бүрд нэгдүгээр байранд орсон багуудыг Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд

оролцуулахаар энэ журмын 2.3.1-д заасны дагуу мэдүүлгийг ирүүлэх.

### **Дөрөв. Баг тамирчид тавигдах шаардлага**

- 4.1. Тэмцээнд оролцох баг тамирчдыг тухайн байгууллагаас томилогдсон багийн ахлагч удирдаж, зохион байгуулна.
- 4.2. Тэмцээнд оролцох тамирчин нь тухайн байгууллагын үндсэн ажилтан бол тухайн байгууллагадаа 3 сараас дээш хугацаанд ажилласан байх буюу 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө ажилд орсон байх шаардлагатай.
- 4.3. Төрийн сангаар суралцаж буй резидент эмч нарыг тухайн байгууллагын нэр дээр оруулах боломжтой. /Тухайн байгууллагадаа нэгээс доошгүй жил ажиллаад резидент эмчийн сургалтад хамрагдсан байх ба байгуулсан гэрээний хуулбарыг хавсаргана/.
- 4.4. Гэрээт ажилтан тэмцээнд орсон тохиолдолд тухайн байгууллагадаа 1 жил болон түүнээс дээш жил ажилласан байх шаардлагатай бөгөөд нийт тамирчдын бүрэлдэхүүнд хоёроос дээшгүй гэрээт ажилтан орж болно.
- 4.5. Эмнэлгийн ажилтан эмнэлэг хооронд шилжсэн тохиолдолд ажилсан сар хамаарахгүй.
- 4.6. Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг тусгай маягтын дагуу бөглөж, баталгаажуулсан байна.
- 4.7. Шатрын тэмцээний мэдүүлэгт тоглогчдын тоглох ширээний дугаарыг зааж өгөх ба тэмцээний үеэр тухайн дугаарыг солих боломжгүй.
- 4.8. Баг тамирчид тэмцээний дүрэм, журам болон зохион байгуулагчийн зааврыг баримтлах бөгөөд хөгжөөн дэмжигчид хувийн сахилга батыг чандлан сахина.
- 4.9. Тамирчид тод ялгарах өнгийн, ар өвөрт нь хувийн дугаар бүхий тоглолтын ижил өмсгөлтэй байна.
- 4.10. Хувцасны өнгө ижил эсвэл төстэй байх тохиолдолд талбайн эзэн буюу зүүн /урд/ талд бичигдсэн баг тоглолтын өөр өмсгөл өмсөнө.

### **Тав. Тэмцээний заавар**

- 5.1 Техникийн зөвлөгөөн дээр тэмцээний төрөл тус бүрээр сугалаа сугалж, оноолт, хугацаа, дарааллыг тогтооно. Тухайн тоглогч /албан хаагчийн иргэний үнэмлэх, томилогдсон тушаал, ажлын үнэмлэхийг шалгаж тэмцээнд оролцох эрх /мандат/ олгоно.
- 5.2. Тэмцээнтэй холбогдон гарч болох маргаантай асуудлыг тухайн байгууллагын багийн ахлагч албан хүсэлт гаргаж зохион байгуулагчид өгч, тэмцээний ерөнхий шүүгчтэй хамтран шийдвэрлэнэ. Талбайн шүүгч зөвхөн тухайн тоглолттой холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.3. Багт гаднын тамирчин оролцсон эсэхийг тухайн төрлийн тэмцээний шүүгч, зохион байгуулагч болон тэмцээнд оролцогч байгууллагын багийн ахлагч, дасгалжуулагч нараас гаргасан хүсэлтээр дахин шалгана. Гомдол гаргах тохиолдолд дэнчин 500.000 /таван зуун мянган/ төгрөгийг зохион байгуулагчийн дансанд байршуулна.
- 5.4. Дэнчинг гомдол гаргах үндэс батлагдсан тохиолдолд тухайн дэнчин гаргасан багт бүрэн буцааж төлнө. Хэрэв гаргасан гомдол үндэслэлгүй бол 400.000

/дөрвөн зуун мянган/ төгрөгийг зохион байгуулагч талд, гомдолд холбогдсон тамирчинд 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийг тус тус өгнө.

5.5. Энэ зааврын 5.3-т заасны дагуу маргаан гарч батлагдсан, гадны тамирчин оруулсан тохиолдолд тухайн байгууллагыг тэмцээнээс бүрэн хасна.

5.6. Маргааны нотлох баримтыг үндэслэн тэмцээнд оролцогч байгууллагын багийн ахлагч нар хуралдаж шийдвэрлэнэ.

5.7. Энэхүү удирдамжаар зохицуулагдаагүй бусад нөхцөл байдал үүсвэл уг асуудлыг тухайн спортын төрлийн олон улсын холбооноос гаргасан дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

5.8. Сагсан бөмбөгийн тэмцээнд талбай дээр эрэгтэй 5, эмэгтэй 5 тамирчин тус бүр оролцоно. Хэсгийн тоглолтууд **эрэгтэй 10, эмэгтэй 8** минутаар 2 ээлж явагдах бөгөөд тэнцсэн тохиолдолд 5 минут сунгаж ялагчийг тодруулна. Финалын тоглолтууд 10 минутаар 2 ээлж явагдах бөгөөд тэнцсэн тохиолдолд 5 минут сунган ялагчийг тодруулна.

5.9. Волейболын тэмцээнд талбай дээр эрэгтэй 6, эмэгтэй 6 тамирчин байх бөгөөд багийн бүрэлдэхүүн дутуу үед тоглолтод оролцохыг хориглоно.

5.10. Тухайн төрөлд оролцож буй баг тэмцээн эхлэх цагтаа талбайд гараагүй тохиолдолд 5 минут хүртэл хүлээх бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн багийг хожигдсонд тооцно.

5.11 Тэмцээнд оролцож байгаа баг өөрийн тамирчдыг "Тамирчдын гэнэтийн ослын даатгал"-д хамруулан оролцуулж болно. Даатгалд хамруулах асуудлыг өөрсдийн сонголтоор шийдвэрлэнэ.

### **Зургаа. Дүгнэх, шагнал урамшуулал**

6.1. Тэмцээний зохион байгуулалтын хураамжид байгууллага тус бүр 5.0 сая төгрөгийг техникийн зөвлөгөөн болох өдөр бэлнээр хураалгана.

6.2. Медалийг сагсан бөмбөг, волейболын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 10 тамирчин, E-sport төрөлд 6 тамирчин, шатар, ширээний теннисийн төрөлд эрэгтэй эмэгтэй тус бүр 3 тамирчнаар, дартсын төрөлд 3 тамирчнаар тооцож олгоно.

6.3. Тэмцээний бүх төрлийн нийлбэр дүнг бага онооны системээр дүгнэнэ. Тэмцээний бүх төрөлд оноо өгөх байдал: I байр 1 оноо, II байр 2 оноо, III байр 3 оноо, IV байр 4 оноо, V-VIII байр 5 оноо, IX-XII байр 9 оноо, XIII-XIV байр 13 оноо, XV-XVI байр 15 оноо тус тус байна.

6.4. Энэхүү зааврын 4.2-4.6 дахь заалтыг зөрчсөн баг, тамирчныг тухайн төрлийн сүүлийн байранд орсонд тооцож 15 оноо өгнө.

6.5. Зарим төрлийн тэмцээн ажлын өдрүүдэд таарч байгаа тул тэмцээнд оролцож байгаа албан хаагч нарыг тухайн өдрийн ажлаас чөлөөлөх, оролцох нөхцөл боломжоор хангахыг тухайн байгууллагын багийн ахлагч, удирдлага хариуцна.

6.6. Тэмцээнд оролцогч байгууллага нь оролцоогүй тэмцээний төрөл тус бүрд хамгийн сүүлийн байранд орсонд тооцож 15 оноо өгнө.